

ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ОНЦЛОХ АЖЛЫН МЭДЭЭ

2021-11-24

Хараат

Монгол Улсын Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн “Үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх хуваарь батлах тухай” А-76 дугаар тушаал, Аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн “Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготнотой энгийн механик аргаар тэмцэх ажлыг зохион байгуулах тухай” А/369 дүгээр захирамж, Сумын Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн “Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготнотой энгийн механик аргаар тэмцэх ажлыг зохион байгуулах тухай” А/93 дугаар захирамжаар ажлын хэсгийг томилон үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг сумын 4 багийн нутаг дэвсгэрт оготно ихээр тархсан талбайд хийж гүйцэтгэлээ. Нийт 65 хүний бүрэлдэхүүнтэй, 8 тээврийн хэрэгсэлтэй, Баян-Уул, Адуун чулуун, Замын-Улаан, Хараат гэсэн 4 хяналтын цэгийг байгуулж, малчдын саналд тулгуурлан 7000га талбайд энгийн механик аргаар устгалын ажлыг хийж гүйцэтгэлээ. Томилогдсон ажлын хэсгийн гишүүд 3 удаа ажил гүйцэтгэж буй талбайд очиж хяналтыг хийсэн.

Төсөвт өртөг: Аймгийн ХХААГ-аас 7,210,000.00 төгрөгийн хуваарилагдсанаас эхний ээлжинд 70% буюу 5,047,000.00 төгрөг орж ирснээс хяналтын ажлын зардал 409,360.00 үлдэгдэл 4,637,640.00 төгрөгийг 4 багт хуваан олгосон. Нийт шатахууны зардалд А92 бензин 450л, дизель түлш 980л зарцуулсан. **Ажиллах хүч:** Ажиллаж байгаа албан хаагчид, иргэдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулан, хамгаалалтын хувцсыг зохих журмын дагуу өмсгөж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгсөн.



Худалдан авах ажиллагааны АЗ сертификат олгох сургалтад 3 хүн тэнцлээ.

Үндэсний статистикийн хорооноос 5 жил тутамд зохион байгуулдаг аж ахуйн нэгж байгууллага, хуваараа хөдөлмөр эрхлэгчийн тооллого 2021 оны 11-р сарын 01-нээс 11-р сарын 21-ний дотор 25 аж ахуйн нэгж байгууллага, 9 хувиараа хөдөлмөр эрхлэгч нар тооллогод 100 хувь хамрагдлаа.

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЫН ХҮРЭЭНД:

Сургууль болон дотуур байрандаа боловсон ариун цэвэрийн өрөөтэй болох ажлыг “Мөнхийн үргэлжлэл” ХХК амжилттай хэрэгжүүлэн бүтээн байгуулалтын ажил өрнөж байна. Газар дээр нь гүний усны хайгуул шинжилгээ хийгдэж ариун цэвэрийн өрөөний зураг төсөл гаргасан. Одоогоор барилгын ажил баригдаад гүний худаг гаргах өрөмдлөг хийгдэж газрын гүний 80метрээс ус гаргаад байна.

Ажлын явцын зургуудаас:



БҮГДЭЭРЭЭ ХУРИМТЛУУЛАЯ АЯН ҮРГЭЛЖИЛСЭЭР



БҮТЭЭЛЧ АЖИЛ

Сургуулийн ажилчид дотуур байранд галын булан болон галаас хамгаалах хэрэгслүүдийг стандартын дагуу хийж бэлтгэн байршууллаа.

БУСАД

Хичээл сургалтын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Энэ сард мэргэжлийн Дуу хөгжмийн багш Ш.Бадарч болон бага ангийн багш Ц.Сүрэнжав нар шинээр ажилд орон ажиллаж байна.



ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР